



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014. 06. 12 № 01158 ЧАТ-ЖАТ/2014/01-ЖА

Г Зөрчил арилгуулах тухай Г

“Эрүүл мэндийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагаа, үр дүн”-д нийцлийн аудит хийх явцад дараах зөрчил илрэлээ. Үүнд:

1. Аудитын явцад ЭМДС-ийн санхүүжилтаар “Залуус-21” төвийг байгуулах, тохижуулах, хөрөнгө эд хогшил авах ажилд 124.5 сая төгрөг зарцуулсан байна.

2. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн Сангийн хөрөнгө хуваарилах тухай 162 дугаар тушаалын 10.8-д заасан “УИХ-ын гишүүдэд чиглэсэн эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтлалыг танилцуулан, хууль батлуулахад дэмжлэг авах нөлөөллийн арга хэмжээ” гэсэн заалтын дагуу ЭМСайдын 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн баталсан “УИХ-ын гишүүдэд чиглэсэн эрүүл мэндийн салбарын багц хуулийн үзэл баримтлалыг танилцуулан хууль батлуулахад дэмжлэг авахад хийгдэх ажлын удирдамж”-аар ЭМДС-аас 43.0 сая төгрөгийн санхүүжилтийг авлага үүсгэн 2013 оны 9 дүгээр сарын 3-нд Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэнд олгосон байна.

3. ЭМСайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 1.2.4.5-д заасан “Эхэд ээлтэй хамт олон эрүүл мэндийн байгууллага шалгаруулж урамшуулалт олгох” гэсэн заалтын дагуу ЭМСайдын 2013 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 107 тоот тушаалаар Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд, Булган, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Увс аймгуудын Эрүүл мэндийн газруудад нийт 2.5 сая төгрөгийн шагнал, урамшуулалт олгосон байна.

4. ЭМСайдын 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 162 дугаар тушаалын 1.1.4 -т заасан “Гэнэтийн болон онцгой байдал, яаралтай арга хэмжээний нөөц зардал” гэсэн заалтын дагуу ЭМСайдын 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 109 тоот тушаалаар Улсын клиникин төв эмнэлэг болон Булган, Ховд аймгуудын Эрүүл мэндийн газруудад нийт 1.2 сая төгрөгийн шагнал, урамшууллыг ЭМД Сангаас 2013 оны 10 дугаар сарын 4-ний өдөр олгосон байна.

Дээрх тушаалууд нь “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ын 1.2-т заасан “Сангийн хөрөнгө нь Тамхины хяналтын тухай хуулийн 10.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2-т заасан зориулалтаар зарцуулна” гэсэн заалтыг зөрчжээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “… алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өг байна.

Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2014 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн дарга Н.Удвал, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Д.Төмөрбаатар нарт даалгав.

ШИНЖЭЭЧ

Б.БИЛЭГТ

